

ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ХҮНС, ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭР, ХОРШООНЫ АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН
А.ЦЭВЭЭНДУЛАМЫН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Бие лэлт ийн хувь
	1	2	3	4	5	6	7
Зорилт 1. Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх замаар хүн амын хэрэгцээ хангамжийг сайжруулж, хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг дээшлүүлнэ.							
1.	Арга хэмжээ 1.1. “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөнийг үргэлжлүүлэн өрнүүлж, гол нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэл, хангамжийг нэмэгдүүлэх АЗД-аас СЗД-тай хамтран ажиллах гэрээний 8 дугаар зорилт 8.3.1 дэх заалт	Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэлийн хэмжээ, мян. тн, хүн амын хэрэгцээ хангамжийн хувь	-	Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэлийн хэмжээг 10 хувиар нэмэгдүүлэх	Хүнсний бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэл, хангамжийн урьдчилсан гүйцэтгэл нь хүн амын хэрэгцээт мах 25,5 мян.тн, сүү 32,78 мян.тонноор дотоодын үйлдвэрлэлээр хангасан.	2025.01.01- 2025.12.15	100
2.	Арга хэмжээ 1.2. Хүнсний	Дэмжлэгт	Хоол	Хүнсний үйлдвэр	Сумын Засаг даргын 2025	2025.01.01-	100

	үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх АЗД-аас СЗД-тай хамтран ажиллах гэрээний 8 дугаар зорилт 8.3.2 дахь заалт	хамрагдсан үйлдвэр, аж ахуй нэгжийн тоо, дэмжлэгийн хэмжээ	үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 1 аж ахуйн нэгжид Хоршоо хөгжүүлэх сангаас зээл олгосон	эрхлэгчдэд хөнгөлөлттэй зээл болон (дэд бүтэц, ажлын байр, түрээсийн хөнгөлөлт гэх мэт) бусад хэлбэрийн дэмжлэг үзүүлсэн байна.	оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн “Хүүхдийн төлөө илүү хариуцлагатай, сонор байцгаая” уриан дор 8 нэрийн хүнсний дэлгүүр, эм ханган нийлүүлэх байгууллагын хамтарсан зөвлөгөөны удирдамжийн дагуу зөвлөгөөнд оролцож 19 аж ахуйн нэгжүүдийн захирал нарт “Хүнсний бүтээгдэхүүний шошгололт, сав боодолд тавих шаардлага болон тусгай зөвшөөрөл”-ийн талаарх сургалт орж, боршур тараан ажиллаж, гарын үсэг зуруулан баримтжуулан ажилласан. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нарт зээл олгоогүй. Талх нарийн боовны чиглэлээр үйл ажиллагаа эхлүүлж байгаа иргэнд Бизнес хөгжлийн төвд хөнгөлөлттэй үнээр өрөөг түрээслүүлж, шинээр ажлын 2 байр бий болсон. “Импортын хүнсний худалдаалалт-хяналт” арга	2025.12.15	
--	---	---	---	--	--	------------	--

					хэмжээ улс орон даяар зохион байгуулагдаж байгаатай холбогдуулан аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрын Хяналтын албаны дарга Д.Лхагважав нь импортын хүнсний худалдаа хяналтын талаар, Хүнсний худалдааны Улсын байцаагч Э.Есөн-Эрдэнэ, хүнсний үйлдвэрлэлийн хяналтын Улсын байцаагч Б.Пагам нартай хамтран импортын хүнсний худалдаалалт, баримт бичгийн хяналт, шошгололтын талаар суманд хүнсний дэлгүүрийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 21 аж ахуйн нэгж, иргэдэд сургалт мэдээлэл өгч ажилласан.		
3	Арга хэмжээ 1.3. Хүн амын эрүүл мэндийг хамгаалах зорилгоор хүнсний зориулалтын бус савны хэрэглээг бууруулах АЗД-аас СЗД-тай хамтран ажиллах гэрээний 8 дугаар зорилт 8.3.8 дахь заалт	-Хүнсний зориулалтын бус савны хэрэглээнээс татгалзсан айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагын тоо	2024 онд сумын 1, 2, 3, 4 дүгээр цэцэрлэгүүдийн хуванцар савны хэрэглээг бууруулсан.	Ерөнхий боловсролын 1, 2 дугаар сургуулийн Хүнсний зориулалтын бус савны хэрэглээг бууруулсан байна.	Ерөнхий боловсролын 1, 2 дугаар сургуулийн Хүнсний зориулалтын бус савны хэрэглээг 10 хувиар бууруулсан. Мөн сумын бүх нийтийн хурлаар хүнсний зориулалтын савны тэмдэг тэмдэглэгээний талаар 122 иргэнд боршур тарааж,	2025.01.01-2025.12.15	100

					зөвлөгөө өгч ажилласан. Сумын Засаг даргын 2025 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн баталсан “Эрсдэлийн үнэлгээ хийх” удирдамжийн дагуу Гэр бүл нийгмийн халамжийн ажилтан, Нийгмийн бодлогын мэргэжилтэн, Эрэн хайх аврах бүлгийн аврагч нартай хамтран ерөнхий боловсролын 1, 2 сургуулийн үдийн цайны гал тогоо, 2 дотуур байрны гал тогоо, 4 цэцэрлэгийн гал тогоогоор орж эрсдэлийн үнэлгээ хийхэд хүнсний зориулалтын бус савны хэрэглээг 50 хувь бууруулсан байна.		
4	Арга хэмжээ 1.4. Сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа хүнсний худалдааны цэг, салбаруудаас 7 хоног бүр хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний нөөцийн мэдээг нэгтгэн авч, тухай бүр үнэн зөв бодитой мэдээлж, хангамж, нийлүүлэлтийн тэнцлийг	Хүнсний бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийн тэнцэл тооцож ажилласан эсэх	Хүнсний худалдааны цэг, салбаруудаас 7 хоног бүр хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний нөөцийн мэдээг нэгтгэн авч, тухай бүр үнэн	Тэнцлийг үйлдвэрлэл, худалдааны тоо хэмжээнд үндэслэн улирал тутам бодитой гаргасан байна.	Суманд үйл ажиллагаа явуулдаг томоохон 10 хүнсний худалдааны цэг, салбаруудаас 7 хоног бүр хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний нөөцийн мэдээг нэгтгэн авч, тухай бүр үнэн зөв бодитой мэдээллэж ажилласан. Хүнсний тэнцэлийг жишсэн	2025.01.01- 2025.12.15	100

	үйлдвэрлэл, худалдааны тоо хэмжээнд үндэслэн улирал тутам бодитой тооцож ажилласан байх.		зөв бодитой мэдээллэж ажилласан.		хүн амд шилжүүлэн бодьтой гаргаж Хүнс, хөдөө аж ахуйн газар луу хүргүүлсэн.		
5	Арга хэмжээ 1.5. “Намрын ногоон өдрүүд-2026” улсын хэмжээний нэгдсэн арга хэмжээний хүрээнд сум орон нутагтаа үзэсгэлэн худалдаа зохион байгуулж, шалгарсан бүтээгдэхүүнийг улс, бүс, аймгийн үзэсгэлэн худалдаанд оролцуулахад дэмжлэг үзүүлэх	-Улс, бүс, аймаг сумын үзэсгэлэн худалдаанд оролцуулсан иргэн, аж ахуйн нэгжийн тоо -Дэмжлэг үзүүлсэн байдал -Борлуулалтын хэмжээ	“Намрын ногоон өдрүүд-2025” улсын хэмжээний нэгдсэн арга хэмжээний хүрээнд сумандаа үзэсгэлэн худалдаа зохион байгуулж ажилласан.	“Намрын ногоон өдрүүд - 2026” арга хэмжээг сумандаа зохион байгуулсан байна.	Суманд үйл ажиллагаа явуулж буй жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч иргэн, аж ахуй нэгжүүдийн бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчлах, борлуулах зорилгоор жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг “Хужиртад үйлдвэрлэв-2025” Намрын баяр 2025 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр амжилттай зохион байгуулсан. “Хужиртад үйлдвэрлэв” намрын баярт 11 иргэн, 1 ААН оролцсон. 1. Нийт борлуулалт 5,961,000 төгрөг 2. Оролцсон төрөл а. Модон эдлэл, эрээлэх урлаг b. Төмс, хүнсний ногоо c. Айраг, сүү, цагаан идээ d. Гар урлал, эсгий, хувцас e. Найман шимтийн тос 3. Нийт 2,640,000 төгрөг	2025.01.01-2025.09.12	100

					зохион байгуулалт, шагналд зарцуулсан. 4. Ивээн тэтгэгчээр: 1. Дулаан 6 дугаар багийн аймгийн аварга малчин Амаржаргалын Мягмарсүрэн 300,000, 2. Хужирт цагаан ХХК 300,000, 3. Бэрх 3 дугаар багийн Улсын аварга малчин Болоожийн Санжаасүрэн 900,000 төгрөгийн тус тус хандив өгсөн. 2025 оны 09 дүгээр сарын 19-21-ний өдрүүдэд Өвөрхангай аймгийн Түншлэл-2025-д суманд үйл ажиллагаа явуулдаг Амарбаясгалант дорж ХХК-ийг оролцуулсан. Найман шимтийн тос, ванны хөөс, ванны давс зэрэг бүтээгдэхүүнийг худалдан борлуулсан. Мөн “Хужирт цагаан” ХХК нь 2025 оны 09 дүгээр сарын 22-28-ны өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулагдсан “НАМРЫН НОГООН ӨДРҮҮД-		
--	--	--	--	--	---	--	--

					ҮНДЭСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ 2025” арга хэмжээнд амжилттай оролцож Хангайн бүсийн “ШИЛДЭГ АЖ АХУЙН НЭГЖ”-ээр тодорсон.		
Зорилт 2. Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлээр төсөл хөтөлбөрийн хээгжилтэнд хяналт тавих, үр дүнг тооцох, хяналт тавих							
6.	Арга хэмжээ 2.1. "Хоршоо хөгжүүлэх сан"-гийн эргэн төлөлтийг сайжруулах, чанаргүй зээлийн хэмжээг бууруулах АЗД-аас СЗД-тай хамтран ажиллах гэрээний 4 дүгээр зорилт 4.2.1 дэх заалт	Гэрээний хугацаа хэтэрсэн, найдваргүй зээлийн үлдэгдэл (төгрөг), гэрээний хугацаа хэтрэлт, найдваргүй зээлийн хувийн жин (хувиар)	-	Гэрээний хугацаа дуусгавар болсон, найдваргүй зээлийн үлдэгдлийг 20 хувиар бууруулж, гэрээний хугацаа дуусгавар болсон, найдваргүй зээлийн хувийн жин 6 хувьд хүргэсэн байна.	Гэрээний хугацаа дууссан найдваргүй зээлийн үлдэгдэл 2024 оны жилийн эцсээр 18,132,664 төгрөг байсан. 2025 оны жилийн эцсийн байдлаар 7,167,151 төгрөг болж 61 хувиар буурсан байна.	2025.01.01-2025.12.15	70
7	Арга хэмжээ 2.2. Хоршоо хөгжүүлэх сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, хэрэгжилтэд хяналт үнэлгээ хийж, хугацаа хэтэрсэн зээлийн өрийг барагдуулах АЗД-аас СЗД-тай хамтран ажиллах гэрээний 4 дүгээр зорилт 4.2.7 дахь заалт	-Хяналт үнэлгээнд хамрагдсан хоршоодын тоо -Зөрчил арилгасан зээлдэгчийн тоо -Зөрчлийг бууруулсан хувь	Сумын хэмжээнд 2024 оны жилийн эцсийн байдлаар чанаргүй зээлийн хэмжээ 6,98 сая төгрөг байна.	Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдлийг урд оноос 20 хувиар бууруулсан байна	Сумын хэмжээнд 2025 оны хагас жилийн байдлаар чанаргүй зээлийн хэмжээ 2,463,966 төгрөг байна. Сумын Засаг дарга, ЗДТГ-ын дарга нартай хамтран “Хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын дагуу хоршоог	2025.01.01-2025.12.15	100

					хөгжүүлэх сангийн чанаргүй зээлийг бууруулж, эргэн төлөлтийг сайжруулах чиглэлээр арга хэмжээг авч, иргэд аж ахуйн нэгжтэй холбогдон ажиллаж байна. Хугацаа хэтэрсэн зээл 2024 онд 18,132,664 төгрөг байсан бол 2025 оны жилийн эцсийн байдлаар 12,085,281 төгрөг болж буурсан. 2022-2023 онд Хоршоог хөгжүүлэх сангаас 4 аж ахуй нэгж, 1 хоршоо, 5 иргэнд нийт 290,000,000 төгрөгийн зээл олгосон байна. 2025 онд дээрх 10 зээлдэгчээс 1 аж ахуйн нэгж, 1 иргэн нь зээлээ хугацаанаасаа өмнө бүрэн төлж дуусгасан. 2025 оны 10 дугаар сарын 14-ны өдөр Хоршоог хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөд хяналт тавих Хяналтын зөвлөлийн гишүүдтэй хамтран хоршоог хөгжүүлэх сангаас зээл авсан 4 иргэн, 4 аж ахуйн		
--	--	--	--	--	--	--	--

					нэгжээр орж хяналт тавин ажилласан.		
Зорилт 3. “Иргэн, аж ахуйн нэгж, хоршоонд арга зүйн зөвлөгөө өгч хамтран ажиллах”							
8	Арга хэмжээ 3.1. Иргэн, аж ахуйн нэгж, хоршоонд арга зүйн зөвлөгөө өгч, чадавхижуулах ажлыг зохион байгуулах Албан тушаалын тодорхойлолт 3 дугаар зорилт 1 дэх заалт	Хуульд нийцсэн арга зүйн зөвлөмжөөр хангасан байна.	Суманд үйл ажиллагаа явуулдаг 3 аж ахуйн нэгжүүдэд арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.	Иргэн аж ахуйн нэгж хоршооны талаарх эрх зүйн мэдлэгтэй болсон байна.	Суманд үйл ажиллагаа явуулдаг 4 аж ахуйн нэгжид зөвлөгөө өгч ажилласан. Төрөөс малчид, мал аж ахуйн үйлдвэрлэлийн талаар хэрэгжүүлж байгаа бодлого, үйл ажиллагааг танилцуулах, малчид, мал аж ахуй эрхлэгчдийн тэргүүн туршлагыг солилцох, мал сүргийг эрүүлжүүлэхэд малчдын анхаарах асуудал, мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамрагдаж байгаа байдал, малын үүлдэр угсааг сайжруулахад юуг анхаарах, цаашдын зорилт, малын гаралтай бүтээгдэхүүнийг боловсруулж зах зээл нийлүүлэх, төсөл хөтөлбөртэй хэрхэн хамтран ажиллах талаар мэдлэг олгох, мөн хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, малчдад хоршооны талаарх	2025.01.01-2025.12.15	100

					мэдээлэл хүргэх, зээлийн батлан даалтын сангийн талаарх мэдээлэл хүргэх, тэдний санал хүсэлтийг хүлээн авах зорилгоор 2025 оны 06 дугаар сарын 07-ний өдөр “Малчдын зөвлөгөөн-2025”-ыг амжилттай зохион байгуулж 453 малчин хамрагдсан. Малчдын зөвлөгөөнд Боловсролын яамны эрүүл мэндийн асуудал хариуцсан зөвлөх, Бор аварга сангийн тэргүүн, аймгийн ХХААГазар, Хоршоологчдын холбоо, Зээлийн батлан даалтын сан, Монгол ВИ-ТИ-НЕТ төрийн бус байгууллагын малын их эмч, МУСТА Дуучин Г.Машбат, МУСТА Дуучин Г.Эрдэнэтунгалаг, сумын удирдлагууд болон мэргэжилтнүүд оролцсон. Зөвлөгөөнд Хөдөө аж ахуйн салбар, Улсын аварга малчдын тэргүүн туршлага, хууль эрх зүй, нийгмийн даатгал, татвар, бэлчээр газар тариалан, эрүүл мэнд, хөдөлмөр нийгмийн		
--	--	--	--	--	---	--	--

					халамжийн талаар холбогдох албан хаагчдын оролцуулан малчдад мэдээлэл хүргэж хамтран ажилласан. Мөн мал маллахын хажуугаар жижиг дунд үйлдвэр эрхлэж, бүтээгдэхүүн үйлдвэрлэж хэрхэн орлогоо нэмэгдүүлэх талаар Бэрх 3 дугаар багийн малчин Г.Хуягсүрэнг оролцуулан малчдад мэдээлэл хүргэж хамтран ажилласан.		
9	Арга хэмжээ 3.2. Иргэдийг нөхөрлөл, хоршоо байгуулж ажиллахад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч ажиллах Албан тушаалын тодорхойлолт 3 дугаар зорилт 2 дахь заалт	Иргэдийг нөхөрлөл, хоршоо байгуулж ажиллахад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч ажилласан байна.	Нөхөрлөл, хоршоо байгуулах хүсэлтэй иргэдэд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч ажилласан	5 Иргэнд нөхөрлөл, хоршоо байгуулж ажиллахад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч ажилласан байна.	Шинээр хоршоо байгуулах хүсэлтээ байгаа 5 хоршооны 13 иргэнд арга зүйн зөвлөгөө өгч, туслалцаа үзүүлж ажилласан. Хоршоо байгуулахад хэрэгтэй бүрдүүлэх баримт бичгийг иргэн бүрт хэвлэж өгсөн.	2025.01.01-2025.12.15	100
10	Арга хэмжээ 3.3. "Шинэ-Хоршоо" хөдөлгөөнийг эрчимжүүлж, санал санаачилгатай малчдыг бүх талаар дэмжих, холбогдох ТББ, мэргэжлийн холбоодтой	- Дэмжлэгт хамрагдсан хоршооны тоо, - Хөнгөлөлттэй зээлийн хэмжээ (тэрбум төг) - Зохион	Сумын хэмжээнд 2024 онд нийт 5 хоршоо 828,5 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлэнд	Суманд шинээр байгуулагдсан малчны хоршоодыг хөнгөлөлттэй зээлийн болон мэргэжил арга	2025 онд шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд Уужим авзага, Агш бэрх, Дэвжих олон бүрд, Лууст гэсэн 4 хоршоо шинээр байгуулагдсан. Мөн Хаан банкнаас Товгийн ширээ,	2025.01.01-2025.12.15	100

	хамтран хоршоодыг чадавхжуулах сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах АЗД-аас СЗД-тай хамтран ажиллах гэрээний 8 дугаар зорилт 8.4.3 дахь заалт	байгуулсан сургалт, арга хэмжээ, Хамрагдсан хоршоодын тоо	хамрагдсан байна.	зүйн дэмжлэг үзүүлж, чадавхжуулсан байна.	Цоохор шар малгайт, Агш бэрх, Гэрсэнд жалайр, Лууст гэсэн 5 хоршоо нийт 616.500.000 төгрөгний хөнгөлөлттэй зээл авсан байна. 2025 оны 6 дугаар сарын 07-ны өдөр “Малчдын зөвлөгөөн-2025” зохион байгуулагдаж, 453 малчин хамрагдсан. Зөвлөгөөнд аймгийн Хоршоологчдын холбооны тэргүүн З.Баярсайхан, Зээлийн батлан даалтын сангийн аймаг дахь салбарын захирал Д.Бямбадолгор нарыг урин оролцуулж малчид, хоршоологчдод зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан. Зөвлөгөөнд малчдын 14 хоршооны малчид оролцсон. Монгол Улсын засгийн газрын агентлаг Жижиг дунд үйлдвэрийн газар, 21 аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газартай хамтран		
--	--	---	--------------------------	--	---	--	--

					Өвөрхангай аймагт зохион байгуулсан “Хоршоологчдын зөвлөгөөн”-нд 2025 оны 10 дугаар сарын 04-нөөс 06-ны өдөр хүртэл 3 хоногийн хугацаанд сумын жишиг хоршоо болох Жамбал талбиу эрдэнэ хоршооны дарга Ц.Доржхандтай хамтран оролцсон.		
Зорилт 4. Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэгжүүлж ажиллах							
11	Арга хэмжээ 4.1 Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх. Албан тушаалын тодорхойлолт 5 дугаар зорилт 6 дахь заалт:	-Хууль ёсны үүрэг даалгаврыг цаг тухай бүрт биелүүлэх Албан хэрэг хөтлөлтийн стандартыг хэрэгжүүлж, мэдлэг чадвараа дээшлүүлсэн байна.	Албан хэрэг хөтлөлтийн стандартыг зохих түвшинд судалж, 2024 онд Өвөрхангай аймгийн Архивын тасгийн сургалтад хамрагдсан.	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн дагуу урд оны материалыг архивлан холбогдох албан хаагчид хүлээлгэн өгөх, өргөдөл гомдлыг хугацаанд нь шийдвэрлэх	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн дагуу урд оны материалыг архивлан холбогдох албан хаагчид хүлээлгэн өгсөн. Хүнс, хөдөө аж ахуйн газраас ирүүлсэн хариутай албан бичгийг хугацаанд хариуг нь хүргүүлж ажилласан. 2025 оны 05 дугаар сарын 07-ний өдөр Өвөрхангай аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрын Захиргаа аж ахуйн албаны дарга Д.Батсуурь-аар ахлуулсан ажлын хэсэг суманд ажиллаж хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтнүүдийн	2025.01.01-2025.12.15	100

					ажилтай танилцаж, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж мөн үндэсний хөтөлбөр болон аймгийн дэд хөтөлбөрийн хэрэгжилт, сумын Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт хүнс, хөдөө аж ахуйн салбарын чиглэлээр тусгасан заалтуудын хэрэгжилтийн явц үр дүн, Аймгийн Засаг даргын сумдын Засаг дарга нартай 2025 онд хамтран ажиллах гэрээнд Хүнс, хөдөө аж ахуйн салбарын чиглэлээр тусгасан заалтуудын хэрэгжилтийн явц үр дүн, хоршоо хөгжүүлэх сангийн программ ашиглалт, зээлийн хүртээмж, эргэн төлөлтийн байдал зэрэг 17 чиглэлээр хяналт шалгалт хийж зөвлөмж, мэдээлэл хүргэж ажилласан.		
12	Арга хэмжээ 4.2 Өөрийн ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлэх, тайлан мэдээг тогтоосон хугацаанд гарган	Төлөвлөгөөний хэрэгжилтийг бүрэн хангасан байна	-	Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, тогтоол шийдвэрийн	Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө болон тогтоол шийдвэрийн биелэлт, хэрэгжиж буй үндэсний хөтөлбөр болон аймгийн дэд хөтөлбөрийн	2025.01.01-2025.12.15	100

	холбогдох мэргэжилтэнд өгөх Албан тушаалын тодорхойлолт 5 дугаар зорилт 8 дахь заалт:			эхний хагас жилийн биелэлт, хугацаатай тайлан мэдээг тогтмол гарган тайлагнах	хэрэгжилтийн төлөвлөгөөг гарган Засаг даргын Тамгын газрын даргаар батлууллан ажилласан. Мөн аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газар болон холбогдох мэргэжилтэнүүдэд тайлан, судалгаа цаг тухай бүрд нь гарган өгч ажиллаж байна.		
--	---	--	--	--	---	--	--

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Бие лэлт ийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.	Арга хэмжээ 1. Ажлын чиг үүрэгт хамаарах болон өөрийгөө хөгжүүлэх сургалтад хамрагдах, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх	Өвөрхангай аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газраас зохион байгуулах сургалт болон бусад сургалт хөтөлбөрт хамрагдсан байна.	-	Хүнс, жижиг дунд үйлдвэр, хоршооны холбогдолтой чадавхижуулах сургалтанд 2-с дээш удаа хамрагдах	1. 2025 оны 04 дүгээр сарын 21-22-ны өдрүүдэд Өвөрхангай аймагт Хүнс, хөдөө аж ахуйн газрын Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтнүүдийн нэгдсэн сургалтад хамрагдсан. 2. Өвөрхангай аймгийн Худалдан авах ажиллагааны газраас зохион байгуулсан АЗ сертификатын сургалтад 2025 оны 03 дугаар сарын 15-16-ны өдрүүдэд 2 хоног хамрагдаж, шалгалтандаа тэнцсэн. 3. Монгол Улсын засгийн газрын	2025.01.01-2025.12.15	100

					агентлаг Жижиг дунд үйлдвэрийн газар, 21 аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газартай хамтран Өвөрхангай аймагт зохион байгуулсан “Хоршоологчдын зөвлөгөөн”, сургалтад 2025 оны 10 дугаар сарын 04-нөөс 06-ны өдөр хүртэл 3 хоногийн хугацаанд сумын Жамбал талбиу эрдэнэ хоршооны дарга Ц.Доржхандтай хамтран оролцсон. 4. 2025 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр Аймгийн стандарт хэмжилзүйн хэлтсээс зохион байгуулсан “Чанарын өдөр”-ийн арга хэмжээ, сургалтад Хужирт цагаан ХХК-ийн гэрээт борлуулагчийн хамт оролцож ажилласан.		
2.	Арга хэмжээ 2. Монгол бичгээр унших, бичих чадвараа сайжруулах	Монгол бичгийн уншиж, бичих чадвараа дээшлүүлсэн байх	Монгол бичгийн анхан чатны мэдлэгтэй.	Монгол бичгийн танхимын сургалтад 1 удаа хамрагдсан байна.	Монгол бичгийн цахим сургалтад 2 удаа хамрагдсан. Засаг даргын Тамгын газраас зохион байгуулж буй ахмадын зөвлөн туслах үйлчилгээний хүрээнд монгол хэл бичгийн багш Нямсүрэнгийн Монгол бичгийн сургалтад тогтмол хамрагдаж байна.	2025.01.01-2025.12.15	100

ТАЙЛАН ХЯНАСАН:

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
(Албан тушаал)

..... /З.ЦЭЦЭГМАА/
(Нэр, гарын үсэг)

.... оны дугаар сарын
(Огноо)

ТАЙЛАН ГАРГАСАН:

ХҮНС, ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭР, ХОРШООНЫ
АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН
(Албан тушаал)

..... /А.ЦЭВЭЭНДУЛАМ/
(Нэр, гарын үсэг)

.... оны дугаар сарын
(Огноо)